



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Г Эрэгтэйчүүд, хөвгүүдийн кабинетийн  
бүтэц, үйл ажиллагаанд тавигдах  
шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрэгтэйчүүд, хөвгүүдийн кабинетийн бүтэц, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэхэд орон нутгийн хөгжлийн сан, олон улсын байгууллага, хандив, тусlamжийн хөрөнгийг татан оролцуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Шаардлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн батлагдсан улсын төсөвт багтаан шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Т.Баярсайхан), мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахыг Эмнэлгийн тусlamжийн хэлтэс (Л.Зэндмаа) нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т даалгасугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



081006

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 08. дугаар сарын 09 өдрийн  
29..... дугаар тушаалын хавсралт

Эрэгтэйчүүд, хөвгүүдийн кабинетийн бүтэц, үйл ажиллагаанд  
тавигдах шаардлага

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрэгтэйчүүд, хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад энэхүү шаардлагын зорилго оршино.
- 1.2. Эрэгтэйчүүд, хөвгүүдийн кабинет нь дараах шаардлагыг хангасан байна.


Хоёр. Кабинетийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Эрэгтэйчүүд, хөвгүүдийн кабинетийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулна.
- 2.2. Кабинетэд ажиллах эмч нь нөхөн үржихүйгээр мэргэшсэн бөөрний мэс засалч (урологич) эсвэл эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн эмч (андрологич) байна.
- 2.3. Кабинетын эмч нь бөөрний мэс заслын эмч, эмэгтэйчүүдийн эмч, БЗДХ/ДОХ-ын эмч, наркологийн эмч, хавдрын эмч, сексопатологич эмч, сэтгэл зүйч настай хамтран багаар ажиллана.
- 2.4. Эрэгтэйчүүд, хөвгүүдийн өвчлөл, нас барагтын судалгаа хийж, мэдээний сан бүрдүүлнэ.
- 2.5. Эрэгтэйчүүд, хөвгүүдийн өвчний эрт илрүүлгийг зохион байгуулах, эмчилж эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- 2.6. Шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлнэ.
- 2.7. Үзлэгийн мэдээ, тайланг сар бүр статистик мэдээллийн албанад өгнө.
- 2.8. Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулна.

Гурав. Кабинетийн өрөө, тоног төхөөрөмжид  
тавигдах шаардлага

- 3.1. Үзлэгийн өрөө нь 12 m<sup>2</sup>-аас багагүй, дуу чимээ тусгаарласан хана, тохилог орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.
- 3.2. Үзлэгийн өрөө нь гадна талдаа нэр, дугаар бүхий хаягжуулалт хийсэн байна.
- 3.3. Үзлэгийн өрөө нь нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.
- 3.4. Кабинет нь дараах тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүнд:
  - 3.4.1. Жин, өндөр хэмжигч,
  - 3.4.2. Даралтны аппарат, чагнуур,
  - 3.4.3. Үзлэгийн оп,
  - 3.4.4. Хаалт /эвхдэг/,
  - 3.4.5. Эмчлүүлэгчийн оп /үйл ажиллагааны зохицуулагатай/,
  - 3.4.6. Сүүдэргүй гэрэл,

- 3.4.7. Орхиометр,  
3.4.8. Алкогольметр,  
3.4.9. Бэлэг эрхтэний дулаан хэмжигч, даралт хэмжигч,  
3.4.10. Давсагны дуран /тусдаа өрөө шаардлагатай/,  
3.4.11. Завсартай троакар (СН 16, 18 баллон катетер багтах),  
3.4.12. Фольегийн гуурс (СН 12, 14, 16, 18, 20, 22, 24) (Баллон),  
3.4.13. Нелатон гуурс,  
3.4.14. Шээдэг сүв тэлэгчүүд 12-26 СН  
3.4.15. Ерөнхий мэс заслын багажны бага иж бүрдэл,  
3.4.16. Эдийн шинжилгээ авах иж бүрдэл,  
3.4.17. Өрөөг халдвартгуйжүүлэх ламп,  
3.4.18. Бээлий, амны хаалт,  
3.4.19. Бусад.



#### **Дөрөв. Кабинетийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

##### **4.1. Дараах сорил, шинжилгээг хийх:**

- 4.1.1. Бэлгийн сэрэл сэдээх сорил /Тэнзодатчик хэрэглэнэ/,  
4.1.2. Өглөөний хөвчрөл шалгах,  
4.1.3. Бэлгийн рефлекс шалгах,  
4.1.4. Төмсөг буусан эсэхийг шалгах,  
4.1.5. Түрүү булчирхайг хуруугаар шалгах (DRE): 50-аас дээш насын эрэгтэй хүн бүрт, шаардлагатай үед 50-аас доош насын хүмүүст хийх,  
4.1.6. Чичиргээт сорил /вибрационный тест/,  
4.1.7. Шээдэг сүв, давсаг дурандах,  
4.1.8. Үрийн шингэнний шинжилгээ хийх,  
4.1.9. Эдийн шинжилгээ хийх,  
4.1.10. Түрүү булчирхайн шүүрэл шинжлэх,  
4.1.11. Бусад.

##### **4.2. Дараах эмчилгээний өвөрмөц аргууд ба мэс ажилбарыг хийх:**

- 4.2.1. Шамраа тайрах (циркумцизи),  
4.2.2. Бүрэн бус (хагас) умранзыг гар аргаар эмчлэх,  
4.2.3. Төмсөгний сойлт хийх,  
4.2.4. Түрүү булчирхайд иллэг хийх (курс эмчилгээний журмаар),  
4.2.5. Давсаг, шээдэг сүвний эмийн эмчилгээ хийх,  
4.2.6. Үрийн суваг дагуу хориг хийх,  
4.2.7. Давсагт хатгалтаар гуурс тавих, байнгын катетер тавих, арчлах,  
4.2.8. Хуухнагийн үхжил, төмсөг, молцог мушгирах үед оношлох, эмчлэх,  
4.2.9. Бусад.